

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн...
дугаартай дотоод албан бичгийн хавсралт

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2024 оны 02 дугаар сарын 29-ний өдөр

№ 3

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын үйл ажиллагаан дахь Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний Стратеги төлөвлөгөөг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Стратеги төлөвлөгөөний 2023 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын “Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ерөнхий чиг үүргийн 1, үндсэн чиг үүргийн 6, 14 зорилтын хүрээнд 53 арга хэмжээ, 86 шалгуур үзүүлэлт хэрэгжүүлэхээр тусгагдсанаас 2023 оны жилийн эцсийн байдлаар, яамны газар, хэлтэс тус бүр хариуцсан ажил үүрэг, чиглэлийн дагуу тайлагнаж, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүн гарлаа.

1. Бүрэн хэрэгжсэн үр дүнтэй буюу 100%-ийн биелэлттэй - 36
2. Холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч ирж байгаа, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90%-ийн гүйцэтгэлтэй -4
3. Дээд шатны байгууллагад өргөн барьсан, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн гүйцэтгэлтэй - 10
4. Боловсруулалтын шатны арга хэмжээ хийгдсэн буюу 50 %-ийн гүйцэтгэлтэй - 1
5. Эрчимжүүлэх шаардлагатай шатанд байгаа буюу 30% гүйцэтгэлтэй- 2
6. Үр дүнгүй буюу 0%-ийн биелэлттэй– 0 заалт байна.

Үнэлгээ хийгдсэн арга хэмжээний арифметик дунджаас үзвэл стратеги төлөвлөгөөний хэрэгжилт **90.1 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэгдлээ. Энэхүү үнэлгээг 2023 оны жилийн эцсийн байдлаарх өссөн дүнгээр гаргасан болно.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд “Үр дүнтэй” буюу зорилт арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтод түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан арга хэмжээ нийт арга хэмжээний 75.4 хувийг эзэлж байна.

Тухайлбал Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсэгт “Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргуулна” гэж заасны дагуу 21 аймаг, 17 байгууллагад нийт 49 зөвлөмж, дүгнэлтийг хүргүүлсэн. Цахим засаглал, төрийн цахим үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр Нийтийн мэдээллийн дэд бүтэц, түүний үйл ажиллагааг зохицуулсан нийт 14 захиргааны актыг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулж, баталсан.

Төрийн захиргааны байгууллага, аймаг нийслэлийн Засаг даргын тамгын газар (нийт 16 яам, 13 агентлаг, 14 аймаг, тэдгээрийн харьяа болон дэргэдэх 106 байгууллагаас мэдээлэл ирсэн)-аас 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах төсөл хөтөлбөрийн судалгааг гаргаж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон 109 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлуулсан нь яам 2023 онд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, амжилттай хэрэгжүүлж ажилласан байна.

Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ерөнхий чиг үүргийн 1, үндсэн чиг үүргийн 6, 14 зорилтын 53 арга хэмжээний 86 шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 2023 оны биелэлтийг 90.1 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэгдсэн.

Харин хэрэгжилт хангалтгүй дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ нь бүрэн хэрэгжээгүй, зорилтод түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ нийт арга хэмжээний 1.7 хувийг эзэлж байна. Эдгээр арга хэмжээг дурдвал:

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 50 хувиар үнэлэгдсэн Стратеги төлөвлөгөөний 1.1-д Харилцаа холбоо, мэдээллийн технологи, цахим засаглал, шуудан, өргөн нэвтрүүлэг, радио давтамж, сансрын холбоо, инновацын бодлогыг төлөвлөх, салбарын хөгжлийн бодлого, хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангах зорилтын хүрээнд 1.1.13-т “Салбарын судалгаа, шинжилгээний төв, лабораториудын үйл ажиллагааг уялдуулах, судалгаа, хөгжүүлэлтийн ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх”-ээр төлөвлөсөн бөгөөд уг арга хэмжээний биелэлтийг Ази, номхон далайн цахилгаан холбооноос зохион байгуулагдсан “Их өгөгдөл ба хиймэл оюун ухаан”, “Юмсын интернэт”, “IPv6” сургалтад Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Үндэсний дата төв УТҮГ, Монголын цахилгаан холбоо ХК, И-Монгол академи УТҮГ-ын байгууллагуудын нийт 118 албан хаагчид, Сүлжээ, хиймэл оюун ухаан технологийн /АРТ-NIA/ онлайн сургалтад МХС ХХК-ны 3-н албан хаагчид, Last Mile Connectivity сургалтад 1, нийт 123 албан хаагчид хамрагдсан. Мөн Мэдээлэл, холбооны өндөр технологи-инновацын кластер байгуулах талаар төслийн хувилбар боловсруулах ажлын суурь судалгааны ажлууд хийгдэж байна.

Мэдээлэл, холбооны өндөр технологи-инновацын кластер байгуулах талаар төслийн хувилбар боловсруулах ажлын суурь судалгааны ажлууд хийгдэж байна. Мэдээллийн технологийн аж үйлдвэрийн парк байгуулах талаар боловсруулсан төслийн хувилбар боловсруулах ажлын хүрээнд “Буянт-Ухаа инновацын төв”-ийг байгуулах саналыг боловсруулж, Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, тэмдэглэл гаргасан. Төслийн хувилбар боловсруулах Ажлын хэсгийг байгуулж, Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулж байгаа бөгөөд энэхүү хуулийн төсөлд Мэдээллийн технологийн кластер төв байгуулах ажил тусгагдсан гэж тайлагнасан нь

Төслийн 1 хувилбар батлуулах ажил бүрэн хийгдээгүй, холбогдох суурь судалгааг хийж байгаа нь тухайн зорилтод түвшиндээ хүрээгүй байна.

“Үр дүнгүй” буюу 30 хувиар үнэлэгдсэн стратеги төлөвлөгөөний 4.1-д Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах зорилтын хүрээнд 4.1.3-т Кибер халдлага, зөрчлийн талаарх мэдээлэл солилцооны тогтолцоог бий болгох, хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд уг ажлын биелэлтийг Кибер халдлага, зөрчлийн талаарх мэдээлэл солилцооны тогтолцоог бий болгох, хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хүрээнд Халдлага зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн захиргааны төв байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам”-ын төсөл болон холбогдох баримт бичгүүдийн хамт боловсруулж байна гэж тайлагнасан нь халдлага зөрчлийн талаар мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх зорилтод түвшиндээ хүрээгүй байна.

Мөн “Үр дүнгүй” буюу 30 хувиар үнэлэгдсэн стратеги төлөвлөгөөний 4.1-д заасан Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах зорилтын хүрээнд 4.1.6-т Кибер аюулгүй байдлыг хангах чиглэлээр шинэ технологи, инновац судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг нэмэгдүүлэх арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд уг ажлын биелэлтийг Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайка-тай хамтран кибер аюулгүй байдлын өнөөгийн байдал, кибер аюулгүй байдлын хүний нөөцийн судалгаа, шинжилгээний ажлыг эхлүүлсэн. Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, зүйлсийн интернэт, үүлэн технологи, машин сургалт зэрэг дэвшилтэт технологийн хэрэглээнээс үүсэх эмзэг байдал, эрсдэлийн суурь судалгааг боловсруулах ажлыг эхлүүлээд байна гэж тайлагнасан нь зорилтод түвшиндээ хүрээгүй байна.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа төлөвлөлтийн дараах алдаа дутагдлуудыг гаргасан байна. Үүнд: Төлөвлөгөөнд туссан зорилтууд тодорхой боловч, зарим арга хэмжээний хувьд шалгуур үзүүлэлт, зорилтод түвшин хоорондоо зөрүүтэйгээс үндсэн зорилт уншигдахгүй, хэрэгжүүлэх арга замыг ойлгомжгүй тодорхойлсон, хэрэгжүүлэхээр тусгагдсан нэг арга хэмжээнд олон шалгуур үзүүлэлтүүдийг тусгасан, зорилт, арга хэмжээ нь хүрэх түвшинтэйгээ уялдаагүй зэрэг алдаа дутагдлууд байлаа. Тухайлбал: 2.2 дахь зорилтын 2.2.1, 3.1 дэх зорилтын 3.1.1, 3.1.2 арга замуудын шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинг зөв тодорхойлж, арга зам шалгуур үзүүлэлтүүдийн хоорондын уялдааг хангах нь зүйтэй байна.

Төлөвлөлт буруу хийгдсэнээс хэрэгжилтийн үр дүнд сөргөөр нөлөөлж байгаа тул стратеги төлөвлөгөөг МУ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан журмыг баримтлан төлөвлөлтийг зөв боловсруулах хэрэгцээ, шаардлага байна гэж дүгнэлээ.

Цаашид стратеги төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй ажлуудыг эрчимжүүлэх талаар үр дүнтэй, арга хэмжээ зохион байгуулж, санхүүжилт шаардлагатай ажлуудын эдийн засгийн тооцоо судалгааг хийн, яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулж ажиллах шаардлагатай болохыг үүгээр уламжилж, цаашид үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх зөвлөмжийг өгч байна.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд болон яамны нэгжүүд хоорондоо уялдаа холбоогүй ажилласан буюу зохион байгуулалтаас үүдэлтэйгээр хэрэгжилт хангалтгүй буюу 30-50 хүртэлх хувиар үнэлэгдсэн арга хэмжээнүүдийн зорилтод түвшинг хангах, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Иймд цаашид төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа ойлгомжтой, тодорхой гаргаж хэвшихийг анхаарах шаардлагатай болохыг дурдан дараах зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна. Үүнд:

Сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллага, яамны газруудад:

1. Дотоод нэгждээ Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг нэгтгэн гаргаж байх албан хаагчдыг тодорхойлж, хариуцах эзэнтэй байхаар зохион байгуулах;
2. Төсөв болон хугацаанаас шалтгаалах ажлын биелэлтийг бодит, дүн шинжилгээтэй, баримтад тулгуурласан байдлаар гаргаж хэвших;
3. Үр дүнд суурилсан бодит нотолгоо бүхий тайлан бичиж ирүүлэх;
4. 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, алдаагүй, тодорхой, ойлгомжтой, эцсийн байдлаар хянагдсан засваргүй тайланг заасан хугацаанд тайлагнаж хэвших;
5. Хэрэгжилт хангалтгүй 30 болон 50 хувьтай үнэлэгдсэн 1.1.13, 4.1.3, 4.1.6 дахь арга хэмжээнүүдийн зорилтод түвшинг бүрэн хангуулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч, ажиллах.
6. Стратеги төлөвлөгөөний 2023 оны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр хангалтгүй үнэлэгдсэн 1.1.13, 4.13, 4.1.6 дахь арга хэмжээнүүдийг яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах.
7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийг мөрдлөг болгон эрчимжүүлэх шаардлагатай ажлуудад анхаарлаа хандуулж, ажил тус бүрийн биелэлтийг ахиулахад шат дараатай арга хэмжээ авч ажиллана уу.

Яамны Бодлого төлөвлөлтийн газарт:

1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тайлантай танилцаж холбогдох баримт материалыг судлан үзэх, үнэлгээ хийх, сайдын зөвлөлийн хуралд танилцуулах зэрэг боломжит хугацааг анхаарч тайлагнаж хэвших;
2. Тайлан нэгтгэлийг хариуцаж буй албан хаагчид сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, яамны нэгжийн удирдлагаар баталгаажуулсан хувийг авч, нэгтгэн эцсийн байдлаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт өгч хэвших;
3. Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа зорилт, арга зам, шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинг МУ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан журмыг баримтлан зөв тодорхойлж, төлөвлөлтийг зөв хийх, төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэгт Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын холбогдох мэргэжилтнийг оруулах,